



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 01/А

Жавхлант

Г Мал сүрэгт үзлэг, ангилалт, ээмэгжүүлэлт 7
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5, 16 дугаар зүйлийн 16.9.2, 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.1, 18.2.3 дахь заалт, төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын хээлтүүлэгчийг үзлэг, ангилалт, ээмэгжүүлэлтэд хамруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Жагдаг

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Гишүүдэд:

Г.Батсуурь

“Дэлгэрбаян эрдэнэ” хариуцлагатай хувьцаат компанийн захирал

Г.Номинцэцэг

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Х.Энх-Уянга

Дэлгэрхаан багийн засаг дарга

Ж.Төртогтох

Наран багийн засаг дарга

Г.Хүрэлбаатар

Сүмбэр багийн засаг дарга

С.Отгонбаяр

Жавхлант багийн засаг дарга

2. Мал сүргийн үзлэг, ангилалт, ээмэгжүүлэлтэд хамруулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Шаравгаваа) бог малын хээлтүүлэгчийг үзлэг, ангилалтад бүрэн хамруулж, дүнг 06 дугаар сарын 26-ны дотор танилцуулахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Э.Жагдаг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.БАТЧУЛУУН



D:Zasag darga /zahiramj-2025/